
УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТАД ХИЙСЭН СУДАЛГАА

Ж.Сайнзаяа
/Үнэн хатамж ТББ/

2015 оны 11-р сар

Судалгааны талаар

Зөвлөх нь Нээлттэй Нийгэм Форумтай байгуулсан гэрээний дагуу Монгол Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад 2015 оны 10-р сарын 15-наас 11-р сарын 5-ны хооронд судалгаа хийсэн болно.

Судалгаанд 2010-2016 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг хамруулсан болно.



Агуулга

- ▶ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын чиг хандлага /2010-2016 он/
 - ▶ 2010-2016 онуудын улсын төсвийн хөрөнгө оруулалтын онцлогоос
 - ▶ 2010-2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтын Засгийн газраас өргөн барьсан болон УИХ-аас баталсан жагсаалтын харьцуулалт
 - ▶ Дүгнэлт
-



Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын Засгийн газраас Улсын их хуралд өргөн барьсан төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалт хир бодитой байдаг, түүнийг ямар байдлаар баталдгийг судалж, үр дүнг бодлого боловсруулагчид болон олон нийт, иргэний нийгэмд танилцуулахад оршино.

Судалгааны хүрээнд Засгийн газраас УИХ-д өргөн барьсан, УИХ-аас баталсан, УИХ-аас тодотгосон төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт болон тэдгээрийн гүйцэтгэлийн жагсаалтыг харьцуулан судалсан болно.




Улсын төсвийн хөрөнгө оруулалтын чиг хандлага /2010-2016 он/




Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өөрчлөлт, 2004-2013 он

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өөрчлөлт 2004-2015




Улсын төсвийн хөрөнгө оруулалт: 2004-2007 онуудад 669.9 тэрбум төгрөг
2008-2011 онуудад 2956.9 тэрбум төгрөг,
2012-2013 онуудад 2243,8 тэрбум төгрөг,
2014-2015 онуудад 2118,9 тэрбум төгрөг байгаа нь хөрөнгө оруулалтын
хэмжээ хурдацтай өсөж байсан ч одоо бууралттай байгааг харуулж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө ба гүйцэтгэл, 2010-2014 он



2010-2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл ба төлөвлөлтийг бүтцээр нь ангилбал



2010-2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтын Засгийн газраас өргөн барьсан болон УИХ-аас баталсан жагсаалтын харьцуулалт

2010-2016 оны хөрөнгө оруулалтын хэмжээ /тэрбум төгрөг/


	дотоодын хөрөнгө оруулалт						
Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Өргөн барьсан	449	688	149	1 934	1384	993	1 510
Баталсан	443	628	1693	2008	1689	1527	,
Тодотгол	580	990	1693	1934	1 377	801	,
Гүйцэтгэл	522	1101	1 277	1 077	1 238	545.3*	,

Тайлбар: 545.3*-улсын төсөв 2015.10.30-ны байдлаар

-* - тодотгол хийгдээгүй, гүйцэтгэл гараагүй



2010-2015 онуудын хөрөнгө оруулалтын баталсан, өргөн барьсан, тодотгосон төсвийн төсөл



2010-2016 онуудын улсын төсвийн хөрөнгө оруулалтын онцлогоос



2010 оны хөрөнгө оруулалтын төслийг баталсан байдал

2010 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний өргөн барьсан болон батлагдсан жагсаалтыг харьцуулж үзэхэд:

- 3Г-аас өргөн барьсан төсвийн төслийн 93 үнэ зөрүүтэй болон (ихэвчлэн) төсөвт өртгөөр бүтнээр нь ахиулан баталсан.
- 3Г-аас өргөн барьсан төсвийн саналд үнийн дүнг нь тэгээр оруулсан 46 төслийг үнэлэн оруулж баталсан.
- 1828,7 сая төгрөгийн 3 төсөл 3Г-аас өргөн бариагүй байхад УИХ-аас шинээр оруулж баталсан.



2011 онд өргөн барьсан ба баталсан хөрөнгө оруулалтын төсвийн зөрүү (салбараар) (сая төгрөг)


Д/д	Салбар	Дүн
1	Тагнуулын ерөнхий газар	2724
2	Төрийн тусгай хамгаалалтын газар	450
3	Цагдаагийн ерөнхий газар	8164,3
	Бүгд	11338,3

Ерөнхий сайдын багцад 3174 сая төгрөг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад 8164,3 сая төгрөгийн төсөл ЗГ-аас өргөн бариагүй байхад УИХ-аас нэмж баталжээ.

2012 онд ЗГ-аас өргөн барьсан нэлээд олон төслийн зардлыг УИХ шууд 50%-иар бууруулж баталжээ.


д/д	Төсвийн Ерөнхийлөн Захирагч, салбараар	төсөвлөсөн		баталсан	
		өртөг	дүн	өртөг	дүн
	I УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН 1 ГАЗРЫН ДАРГА	2349,4	2349,4	1199,7	1199,7
	2 III МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	150	150	75	75
	3 ИҮ ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССИЙН ДАРГА	10	10	5	5
6	ҮИ ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	100,4	100,4	50,2	50,2
7	VIII ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	80,4	80,4	40,2	40,2
8	IX САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	500	500	250	250
9	X СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	35,5	35,5	17,8	17,8
10	ХИЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА	65,9	65,9	33	33
12	XII.4 Мэдээллийн МОНЦАМЭ агентлаг	150	150	75	75
14	XIII МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД	73	73	36,5	36,5
15	XIII.3 Улсын бүртгэлийн ерөнхий газар	4558	3600,6	2700,6	1743,2
16	XIII.4Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв	2431	2431	1414,6	1120
17	XIII.5Оюуны өмчийн газар	250	250	125	125

2013 онд УИХ-аас нэмж баталсан төслүүд



2013 онд нийт үнэ болон нэрийн зөрүүтэй 2500 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ, ЗГ-аас өргөн барьсан төсөл арга хэмжээний жагсаалтад ороогүй 76264,5 сая төгрөгийн 45 төсөл арга хэмжээ УИХ-аар батлагдсан.

2014 онд өөрчлөн баталсан хөрөнгө оруулалтын төсөв (салбараар)



2014 онд хөрөнгө оруулалтын арга хэмжээний 3Г-аас өргөн барьсан 17 төсөл нэр буюу 94513 сая төгрөгийн үнийн зөрүүтэй УИХ-аар батлагдсан бол 259307,7 сая төгрөгийн 131 төсөл арга хэмжээ өргөн барьсан жагсаалтад огт байгаагүй болно.


2015 оны төсвийн тодотголын өөрчлөлт

Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Төсөл арга хэмжээний тоо	Санхүүжих дүн /тэрбум төгрөг/
2015 онд баталсан хөрөнгө оруулалт	428	381.6
ЗГ-н 2015 оны 230-р тогтоолын дагуу шинээр эхлэх ажлуудаас <u>хойшлуулсан</u>	17	-18.6
Гүйцэтгэл удаашралтай байгаа санхүүжилтийг 2016 онд болгон <u>хойшлуулсан</u>	21	-11.5
ШШГЕГ-н өөрийн орлогоос санхүүжихээр <u>нэмсэн</u>	9	3.03
Архивын барилга борлуулсан орлогоос санхүүжихээр <u>нэмсэн</u>	2	1.90
Тодотгосон хөрөнгө оруулалт	422	356.4

2015 онд Хөгжлийн банкнаас санхүүжих хөрөнгө оруулалтын өөрчлөлт


Хөгжлийн банкны хөрөнгө оруулалт	Төсөл, арга хэмжээний тоо	Санхүүжих дүн /тэрбум төгрөг/
2015 онд баталсан хөрөнгө оруулалт	242	794.6
ЗГ-н 2015 оны 230-р тогтоолын дагуу шинээр эхлэх ажлуудаас <u>хойшлуулсан</u>	11	-40.3
Гүйцэтгэл удаашралтай байгаа санхүүжилтийг 2016 онд болгон <u>хойшлуулсан</u>	117	-311.1
Санхүүжилт <u>нэмсэн</u>	8	1.4
Тодотгосон хөрөнгө оруулалт	239	444.6

2015 онд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт



2016 онд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, арга хэмжээ, барилга

байгууламжийн жагсаалт




2016 оны хөрөнгө оруулалт

- ▶ 2016 оны Хөрөнгө оруулалтын төсөвт 30 төсвийн ерөнхийлөн захирагчдаас нийт 2.7 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 1941 төсөл, арга хэмжээний санал ирсэн бөгөөд 2016 онд нийт 562 төсөл, арга хэмжээнд 443.5 тэрбум төгрөгийн барилга, байгууламж, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хөрөнгө оруулалтын ангилал	Санхүүжих дүн /сая.төг/	Эзлэх хувь%
Хөрөнгө оруулалт	390,209.9	87.97
Их засвар	25,747.0	5.8
Тоног төхөөрөмж	27,548.4	6.2
ТЭЗҮ, зураг төсөл	51.8	0.012
НИЙТ	443,557.0	


2016 оны хөрөнгө оруулалт

- Нийт 450 төсөл, арга хэмжээний 316.5 тэрбум төгрөг нь шилжиж байгаа төслүүдийн хөрөнгө оруулалт юм. Үлдсэн төсөл, арга хэмжээ нь 2016 онд шинээр эхлэх буюу 112 төсөл, арга хэмжээнд 127.0 тэрбум төгрөг тусгагдсан байна.




2013-2014
онуудад
эхэлсэн
төслүүд
ихэнхи
хувийг эзэлж
байна.


2015-2016 онуудын хөрөнгө оруулалтаас




ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2012- 2016 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ



ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2012- 2016 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ




ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2012- 2016 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ



2012-2016 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсөл /тэрбум төгрөг/

	2012	2013	2014	2015	2016
Хөгжлийн банк	488.4	1,667.2	1,357.3	794.6	450.0
Улсын төсвийн Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	1,208.4	1,125.2	1,180.9	381.5	443.5
НИЙТ	1,696.8	2,792.4	2,538.2	1,176.1	893.5

2012-2016 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсөл /тэрбум төгрөг/



ДҮГНЭЛТ

2010-2016 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр Засгийн газраас өргөн барьсан төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг УИХ-аар баталсан байдлыг харьцуулан судлахад дараах байдал ажиглагдлаа. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр Засгийн газраас өргөн барьсан төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт болон УИХ-аар баталсан жагсаалт нь өөрчлөлт ихтэй байна.
- Хөрөнгө оруулалтыг салбаруудаар авч үзвэл өөрчлөлт ихтэй, зарим жилүүдэд зарим салбар орхигдсон мэт байх байдал ажиглагдлаа.
- Зарим жилүүдэд жагсаалтанд байгаа төслүүдэд 20%, 30%, 40%-ийг жил дараалан цувуулан баталсан нь эдийн засгийн хувьд ихээхэн алдагдалтай, он дамжсан дуусдаггүй барилгууд бий болох үндэс суурь болсон байх магадлалтай.



ДҮГНЭЛТ

2016 онд:

- Урьд оноос шилжин баригдаж буй барилга байгууламжийг тэргүүн ээлжинд төсөвт тусгах;
- 2016 ондоо дуусах боломжтой төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэх зорилт тавьсан нь энэ асуудалд хариу болохоор харагдаж байна.
- ▶ Сүүлийн жилүүдэд боловсролын салбарт хөрөнгө оруулалт тэргүүлсээр байгаа нь сайшаалтай хэрэг боловч, дагаад урсгал зардал ихээр нэмэгддэг.



ЗӨВЛӨМЖ

- ▶ Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, гүйцэтгэлийг сайжруулахад Засгийн газрын зүгээс улс оронд нэн шаардлагатай, эдийн засгийн болоод нийгмийн үр өгөөж нь судлагдсан өөрөөр хэлбэл, нэн тэргүүний ач холбогдол бүхий төслүүдийг төлөвлөн УИХ-д өргөн барьж, төслүүдийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн зардлыг бүтнээр нь хамгаалж батлуулах нь чухал юм. Төсөлд шаардагдах зардлыг цаг хугацаанд нь бүрэн санхүүжүүлэх нь хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг дээшлүүлэхэд ач холбогдолтой.
- ▶ Засгийн газраас хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн тайлагналтыг сайжруулах шаардлагатай байна.



Анхаарал хандуулсанд баярлалаа.